

УЛС ТӨР

Ж.ЭРДЭНЭБАТЫГ 100 ХУВИЙН САНАЛААР ДЭМЖИВ

II нүүрт

ДЭЛХИЙ

ИХ БРИТАНИЙН ЕРӨНХИЙ САЙДАД ГОРИЛОГЧИД

VI нүүрт

САЙД ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

АН, МАН-ЫН ТОМИЛГОО

АРАЙ Л БИШ ЭЭ

Б.ӨНӨРТӨГТОХ

Улс орноо өрийн хямралаас гаргаж, угжны хурга шиг амьдарч буй монголчууддаа "гоё амьдрал" бэлэглэх амлалт өгч гарч ирсэн МАН-ынхан төр засгаа төвхнүүлэх ажилдаа ханцуй шамлан оржээ. АН-аас ялгаатай нь тэд нэг томилгоог олонхийн хүч түрсэн шийдвэрээр гаргачихдаг учраас хоног хугацаа алдаж хойшоо тавигдахгүй нь сайхан юм. Үндсэндээ Удирдах зөвлөлд байгаа 20 хүний үг, гаргасан шийдвэр хууль мэт хэрэгждэг учраас хэн ч юу ч гэж зөрүүдлээд нэмэргүй нь ойлгомжтой. УИХ-ын даргаар намын дарга томилгооход цөөнгүй хүн эсэргүүцэж байсан ч энэ зөрчил тийм ч хол явж чадаагүй. Хоёр гуравхан хүний

туниж гоморхсон үг юм шиг дуудлаад л өнгөрч байв. Хэн ч дарга болохыг хүсдэг. Төрийн эрхийг үнэмлэхүй авсан намын гишүүн бүхний дотор л нийм бодол явж байгаа нь худлаа биш. Нэг удаа УИХ-д суучихлаа, хоёр дахиа сууж байгаа би яагаад сайд болж болохгүй юм бэ гэсэн хар хорын бодол хурган дарга нараас эхлээд "нялх Сэнгүм"-үүдэд хүртэл байгаа. Тиймдээ ч хөшигний цаана МАН-ынхан сайдын суудал санаархаж, өвөр зуураа хор найруулцааж сууна. Намын лидер улстөрчдийн дотор хүртэл албан тушаалаа булаалдаж хэмлэлдэж байгаа тохиолдол бишгүй олон байгаа. Гэвч, энэ бүхнээ тэд хэзээ ч ил гаргадаггүй.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр +29
Шөнө +19

Л.ПҮРЭВСҮРЭН: АСЕМ-Д 34 ОРНЫ ТӨР ЗАСГИЙН УДИРДЛАГА ИРЭХДЭЭ МЭДЭГДСЭН

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

МАН-ынхаан,
бүтээн байгуулалтаас
татгалзав аа

Н.ПУНЦАГБОЛД

МАН УИХ болоод нийслэлд олонхи болсон болохоор зүгээр захиас хэлэх гэсэн юм. Түүнээс биш өөр ямар нэгэн бодол санаа агуулсангүй. Өчигдөр Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн анхны хуралдаан болж, дарга нараа томиллоо. Нийслэлийн Засаг даргаар Су.Батболд томилгогдсон бол Иргэдийн хурлын дарга нь Ц.Сандуй боллоо. Ингэснээр нийслэлийнхний ажил эхэлж байгаа юм. Тэгвэл Су.Батболд даргын багт өмнө нь АН-ын хэрэгжүүлж байсан төслүүдийг толгой дараалан битгий "цаазлаарай" гэж захимаар байна. Тухайлбал, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн судалгааны төвийнхөн Хурал тогоотыг аялал жуулчлалын цогцолбор болгох төсөл хэрэгжүүлэхээр болоод байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ

МОНГОЛ ГЭР, МОДОН ЭДЛЭЛ ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДЖЭЭ

Б.ЭРХЭС

Дотоодын жижигхэн зах зээлээс хальж үзээгүй, үндэсний гэх тодотголоос өөрөөр борлуулалт багатай байсан үндэсний үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд эрчимтэй сэргэж буй. 2014 оноос Аж үйлдвэрийн яам тусад нь байгуулж, үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжиж, хууль тогтоомжийн орчныг нь бүрдүүлж өгснөөр үйлдвэрлэгчид маань Монголын зах зээлээс хальж гадны зах зээлд гарах, улмаар импортыг орлох чанартай бүтээгдэхүүнийг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологиор үйлдвэрлэх бүрэн боломжтой болсон юм. Тэдний нэг нь "Woodman Furniture" компани. 20 жилийн түүхтэй, Герман технологиор цэвэр модон тавилга, монгол гэр үйлдвэрлэдэг тус компани өнгөргөч сард Монгол Улсынхаа нэрийг дэлхий дахинд дуурсгаж, Монголын уран дархчуудын чадварыг олон улсад гайхуулаад иржээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Су.Батболд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч боллоо

Ж.ОТГОН

НИТХ-ын анхдугаар хуралдаанаар нийслэлийн ИТХ-ын сонгууль явуулсан дүн, шинээр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрч, нийслэлийн ИТХ-ын даргаар нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуйг сонгосон юм. НИТХ-ын даргыг сонгохын өмнө иргэдийн төлөөлөгчид НИТХ-ын даргад нэр дэвшигч Ц.Сандуйгаас 60 тэрбумыг босгох тухай буюу нийтэд тарсан бичлэгийн талаар асуулаа. Төлөөлөгч Ц.Баатархүү "Өнгөрсөн дөрвөн жилд НИТХ-ын хуралдаан байнгын ажиллагаатай болж, хурал-

даан олон нийтэд нээлттэй болсон. Энэхүү нээлттэй байдлыг та ирэх дөрвөн жилд үргэлжлүүлэх үү. Мөн өнгөрсөн сонгуулийн үеэр тантай холбоотой 60 тэрбум төгрөгийн асуудал яригдсан. Энэ талаар маш тодорхой тайлбар хэлэхгүй юу" гэлээ. Харин нэр дэвшигч Ц.Сандуй "НИТХ-ын хуралдааны нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллана. Харин 60 тэрбум төгрөгийн тухайд энэ бол сонгуулийн үеэр гарсан эвлүүлэг" гэв. Түүнчлэн төлөөлөгч Ц.Одонтунгаалаг "Тантай холбоотой 60 тэрбумын асуудлаар хуулийн байгууллага тодорхой шийдвэр гаргаад, та

болон танай намыг буруутай гэж үзвэл хариуцлага хүлээхэд бэлэн үү" гэв. Нэр дэвшигч Ц.Сандуй "60 тэрбум төгрөгтэй холбоотой бичлэг эвлүүлэг гэдэг нь тодорхой болж байгаа. Тийм учраас хуулийн байгууллага үнэн зөв шийдвэр гаргана гэдэгт итгэлтэй байна. Хуулийн байгууллагын гаргасан шийдвэрийг хүндэтгэж, хариуцлага хүлээхэд бэлэн" гэсэн юм. НИТХ-ын дарга асан Д.Баттулга "Та өөрөө манай бичлэг алдагдсан гэдгээ хүлээн зөвшөөрч, бас энэ бичлэг алдагдсан хэргийг шалгуулна гэсэн.

Үргэлжлэл нь II нүүрт



МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ **15400**



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк

	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1995.00	2013.00
ЕВРО	2187.00	2277.00
ИЕН	19.51	20.20

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2002.00	2015.00	ФУНТ	2531.00
ЕВРО	2183.00	2276.00	РУБЛЬ	29.20
ИЕН	19.43	20.62	ЮАНЬ	299.30
				305.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Шинэ гишүүд
30 хоногийн
дотор хөрөнгөө
мэдүүлнэ

УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын 2016 оны сонгуульд ялалт байгуулсан гишүүд, төлөөлөгчид тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ өгөх хуультай аж. УИХ-ын анхдугаар чуулган хуралдаж, УИХ-ын гишүүний бүрэн эрхээ баталгаажуулсан. Өчигдөр НИТХ-ын анхдугаар хурал болж, хурлын даргаа сонгосон тул өчигдрөөс эхлээд 30 хоногийн дотор 2015 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус газарт ирүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хамтран ажиллах асуудлаар УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатар албан бичгийг хүргүүлснээс гадна мэдүүлэг гаргагчдад зорнулсан гарын авлага, зөвлөмжийг хүргүүлжээ.

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Энэ талаараа хуулийн байгууллагад хандсан уу” гэв. Нэр дэвшигч Ц.Сандуй “Энэ талаар Сүхбаатар дүүргийн цагдаагийн байгууллагад хандсан. Гэхдээ 60 тэрбум төгрөгийн тухайд эвлүүлэг гэдэг нь тогтоогдож байгаа. Тийм учраас энэ гүтгэлэг гэдгийг дахин хэлж” гэв.

Э.Бат-Үүл: Та
бүхэн жаахан
даруухан
байгаарай

Ийнхүү төлөөлөгчид асуулт асууж, хариулт авах үеэр нийслэлийн МАН-ынхан даргаа өмөөрч шугуиж байсан учир санал хураахын өмнө нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл “Та нартай юу ч булаацалдаагүй. Сонгуулийн дүнгээ зөвшөөрөөд, та бүхэнд тайван замаар эрх мэдлээ шилжүүлэх ардчиллын гайхамшиг бий шүү гэдгийг хэлж байхад та бүхэн олуулаа орилж, найрал дуу шиг дайрч байгаа нь маш том алдаа. Битгий ийм үйлдэл гарга гэж зөвлөж байна. Та нар янж нь даахгүй шүү. Би дахиад хэлж. Эсэргүүцлийн хөдөлгөөн зохион байгуулах арга, нэр хүнд болоод гуршлагыг гартаа атгачихсан хүмүүс гудамжинд гарчихсан байгаа шүү. Тиймээс битгий ингэж аархуу загнаарай. Би та нарын сайн сайхны төлөө, нийгмийн болоод ардчиллын аюулгүй байдал, эрх ашгийн төлөө хэлж байна. Би сонгуулийн дараа зориуд тайван замаар засгийн эрх шилждэг, энэ ардчиллын гайхамшигийг үзүүлсэн сонгууль боллоо гэдгийг санамсаргүй хэлээгүй. Түүнчлэн энэ НИТХ бол өнөөдөр нийслэлд эхнэрхүндээр парламенттайгаа өрсөлдсөн хурал болж чадсан. Өөрөөр хэлбэл, УИХ-тайгаа өрсөдөхүйд хурал болсон. Тэгэхээр ийм хурлын нэр төрийн асуудал гэж байдаг юм. Гэтэл одоо анхнаасаа л нэр төр нь асуудалд орж, эргэлзээнд орно гэдэг нь аюул байдаг. Та нар үнэмлэхүй олонхи. Тиймээс хэнийг сонгох нь бүрэн эрхийн асуудал. Гэхдээ иргэдийн хурал гэж нэрлэсэн учрыг сайн бод. ИРГЭД-ийн хурал гэдэг юм шүү. Тиймээс ИТХ-ын нэр төрийн асуудал маш чухлаар тавигдах учиртай. Анхнаасаа л ард түмэнд итгэл найдвар төрүүлсэн буюу онцгүй зүйлийн бай болчихоогүй иргэдийн хурал байх ёстой. Гэхдээ нэгэнт л үнэмлэхүй ялсан та бүхэн шийдвэрээ гарга. Тухайн шийдвэрийн дагуу л явна. Учлаарай би бол эсрэг санал өгөх нь ойлгомжтой. Яагаад гэвэл иргэдийн хурлын нэр төрийг унагах хүнийг дэмжихгүй. Д.Баттулгын хэлдэг үзэн. Ц.Сандуйгийн 60 тэрбумыг босгох тухай асуудал олон түмний анхааралд орчихсон ноцтой асуудал. Тиймээс энэ асуудал нь



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

түүнийг дарга болсон ч салахгүй. Тиймээс та бүхэн жаахан даруухан байгаарай. Би хэлж байсан. Алан хядагч шиг нүүрээ нуугаад бүтээн байгуулалтыг эсэргүүцдэг хүмүүсийг би лалар гэж хэлсэн. Харин тэр нь хэн байсныг одоо олж харлаа” хэмэсэн юм. Ийнхүү НИТХ-ын анхдугаар хуралдаан түр завсарласан юм.

Тэргүүлэгчдэд
АН-ын гишүүд
багтсангүй

НИТХ-ын үдээс хойшхи анхдугаар хуралдаанаар төлөөлөгчдөд үнэмлэх, энгэрийн тэмдгийг нь гардуулан өгсөн юм. Түүнчлэн НИТХ-ын тэргүүлэгчдийг сонгох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэлээ. НИТХ-ын хуралдааны дэгийн дагуу 11 төлөөлөгчийг НИТХ-ын тэргүүлэгчээр сонгохоор болсон. Ингээд МАН-аас ес, АН-аас хоёр хүн нэр дэвшүүлэхээр болсон. Гэсэн ч АН-ын бүлэг тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд хүнээ оруулахаас татгалзлаа. Ингэснээр НИТХ-ын тэргүүлэгчдээр МАН-аас нэр дэвшсэн есөн хүнийг дэмжлээ. Үүний дараа нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж, Хотын даргад нэр дэвшигч Су.Батболдыг хуралдаанд оролцогчдын олонхи дэмжлээ.

Нэр дэвшигчийг танилцуулсны дараа төлөөлөгчид асуулт асууж, хариулт авсан юм. Энэ үеэр НИТХ-ын дарга асан Д.Баттулга “1990 оноос хойш анх удаа төлөөлөгч биш хүн нийслэлийн Засаг даргаар томилогдох гэж байна. Яагаад вэ. Үүндээ

төлөөлөгч биш хүн нийслэлийн Засаг даргаар ажиллана гэдэг маш хүндирлэгэй. МАН энд сонгогдсон төлөөлөгчиддөө итгэхгүй байгаа юм уу. Чадахгүй гэж үзэж байгаа юм уу” гэдгийг нэр дэвшүүлж буй намын төлөөлөгчөөс асуусан юм. НИТХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Амарбаясгалан “МАН нэр дэвшигчээ намын олон шатны байгууллагын хурал, гишүүдийнхээ саналд үндэслэн тодруулдаг. Нийслэлийн Засаг даргад нэр дэвшигчийн тухайд намын Удирдах зөвлөл, нийслэлийн МАН болон НИТХ дахь МАН-ын бүлгийн гишүүдийн саналыг үндэслэн тодруулсан. Давуу талын хувьд өмнө нь УИХ-ын гишүүн байсан, нийслэлийн ажлыг УИХ болон Засгийн газартай холбон ажиллах чадвартай, шилдэг боловсон хүчин гэж үзсэн” хэмээлээ. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа төлөөлөгчид нэр дэвшигчид хандан үг хэллээ. Төлөөлөгч Н.Цацралтуяа “Хоёр цаг гаруйнхны өмнө Ц.Сандуй дарга төлөөлөгчдийнхөө эрх ашгийг хангана гэж хэлж байсан. Харин одоо төлөөлөгчдийнхөө үгийг хэлүүлэхгүй, өөр дүр төрх гаргаад сууж байна. Үүн шиг та бас хоёр цагийн дараа өөр дүр төрх битгий харуулаарай. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг үргэлжлүүлээрэй. Хэлсэндээ хүрээрэй” гэв. Төлөөлөгч Д.Амарбаясгалан “Өнгөрсөн хугацаанд олон сайхан ажлууд хэрэгжсэн. Эхлэл нь тавигдсан. Энэ сайхан ажлуудыг үргэлжлүүлэх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр дутуу хийгдсэн, үр дүн багатай байгаа зарим ажлыг дахин зохион байгуулах хэрэгтэй. Түүнчлэн нийслэлийн харьяа байгууллага, дүүргүүд,

...Бидний өвөг
дээдэс, эцэг эхийн
маань асар их
хүч хөдөлмөрийн
үр дүнд нийслэл
сүндэрлэн
боссон. Нийслэлд
шийдвэрлэх олон
асуудлууд бий.
Иргэн бүр тэгш,
амьдрах хөгжих
боломжийг бий
болгохыг би
эрмэлзэж байна.
Хотын эдийн
засаг, үйлдвэр,
хот, дүүргүүдийн
онцлогт бий
болсон эдийн
загийн бодлогыг
хэрэгжүүлнэ...

ялангуяа захын дүүргүүдэд байгаа ажилтнуудын чадварыг сайжруулах, ур чадварыг нэмэгдүүлж, ёс суртахууныг нь шинэ төвшинд гаргах талаар тусгайлан кампанит ажил явуулах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол дээрээ шийдвэр гаргаад байдаг. Дунд шатандаа ямар ч чадваргүй, сэтгэлгүй хүмүүсээр дүүрчихсэн байгаа шүү. Энэ талаар анхаарч ажиллаарай” гэв. Ийнхүү

төлөөлөгчид асуулт асууж, үг хэлсний дараа нийслэлийн Засаг даргаар С.Батболдыг томилохыг дэмжлээ. НИТХ-ын хуралдааны шийдвэрийг өчигдөртөө багтан Ерөнхий сайдад өргөн барихаар тогтсон юм.

Су.Батболд:
Аз жаргалтай
Улаанбаатар
хотыг бий
болгохын тулд
ажиллах болно

Нийслэлийн Засаг даргаар сонгогдсонхоодараа Су.Батболд “Нийслэл хот маань амар тайван байх ёстой. Нийслэлийн үе үеийн удирдлагуудын хичээл зүтгэлийн хүчин Нийслэл хот маань сүндэрлэн босч өдий ээрэгтэй байгаа билээ. Нээлттэй ил тод ажиллахыг шаардаж ажиллах болно. Нийслэл хотын иргэн бүрийн нүднээс аз жаргал гэрэлтэж байхын төлөө ажиллах болно гэдгээ хэлж байна. Бидний өвөг дээдэс, эцэг эхийн маань асар их хүч хөдөлмөрийн үр дүнд нийслэл сүндэрлэн боссон. Нийслэлд шийдвэрлэх олон асуудлууд бий. Иргэн бүр тэгш, амьдрах хөгжих боломжийг бий болгохыг би эрмэлзэж байна. Хотын эдийн засаг, үйлдвэр, хот, дүүргүүдийн онцлогт бий болсон эдийн загийн бодлогыг хэрэгжүүлж, аз жаргалтай Улаанбаатар хотыг бий болгохын тулд ажиллах болно” гэлээ. НИТХ-аас гаргасан энэхүү шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барина. Үүний дараагаар албан ёсоор түүний бүрэн эрхийг баталгаажуулах юм.

МАН-ЫН БАГА ХУРАЛ

Ж.Эрдэнэбатыг 100 хувийн саналаар дэмжив

ЖОТГОН

МАН-ын Бага хурал 15.00 цагийн үед эхэллээ. Бага хуралд нийт 310 гишүүн ирэх ёстойгоос 174 гишүүн хүрэлцэн ирж, 58,3 хувийн ирцтэйгээр хурлыг эхлүүлсэн юм. Хуралдааныг нээж М.Энхболд үг хэллээ. Тэрээр “Сонгуулийн өмнө хуралдсан Бага хурлаар УИХ болон аймаг нийслэлийн ИТХ-д өрсөлдөх нэрсийг тодруулж, мөрийн хөтөлбөрөө баталснаар сонгуулиар ялалт байгуулах буухиаг дагуулсан. Иймд МАН-ын Удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс болон хувиасаа та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлж, амжилт хүсье” гэсэн юм. Бага хурлыг УИХ-ын гишүүн Д.Сумьяабазар даргалж, Н.Амарзаяа дэд даргын үүрэг гүйцэтгэсэн юм. Хуралдааны эхэнд МАН-ын

дарга, УИХ-ын дарга М.Энхболд 2016 оны УИХ-ын болон аймаг орон нутгийн сонгуулийн үйл явц, үр дүнгийн талаар илтгэл тавилаа. Дараа нь Удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлсэн Ж.Эрдэнэбатыг Ерөнхий сайд болгох эсэхийг хэлэлцэв. Бага хурлын өмнө Удирдах зөвлөл ороход Ерөнхий сайдад Ж.Эрдэнэбатаас гадна С.Бямбацогт, Ж.Мөнхбат нар нэр дэвшээд байсан. Гэвч С.Бямбацогт, Ж.Мөнхбат нар сайн дураар нэрээ татсанаар бага хурлаар зөвхөн нэр дэвшигч Ж.Эрдэнэбатыг дэмжих, эсэх асуудлыг хэлэлцэж, 100 хувийн саналаар дэмжлээ. Энэ үеэр бага хурал талархал холбогдуулж МАН-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Г.Ганбаяр мэдээлэл хийсэн юм. Тэрбээр “Өглөө 11.00 цагаас хуралдсан МАН-ын УЗ-ын хурлаар



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.Эрдэнэбатыг дэмжсэн. Бага хурлаар батлагдсан нэрийг УИХ дахь МАН-ын бүлгээр дамжуулж УИХ-д өргөн барина. Түүнчлэн МАН-ын Бага хурлын зарим гишүүнийг чөлөөлөх, зарим гишүүнийг нэмэх асуудлыг хэлэлцэнэ” гэлээ. Мөн тэрбээр “Удирдах зөвлөлийн хуралдаан дээр УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат,

С.Бямбацогт, Ж.Эрдэнэбат нарын нэрийг дэвшүүлсэн. Гэвч улс орны эдийн засгийн байдал хүнд нөхцөлд байна. Тиймээс эдийн засаг, санхүүгийн мөргөжилтэй, орон нутгийн ажил амьдрал мэддэг хүнийг томилох нь зүйтэй юм гэж үзээд УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат, С.Бямбацогт нар нэрээ татаж авсан” гэдгийг

дуулгасан юм. МАН бага хурлынхаа үр дүнгийн талаар өнөөдөр Төрийн ордонд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх юм байна. Мөн энэ удаагийн бага хурлаар зөвхөн Ерөнхий сайдад нэр дэвшигчийг хэлэлцсэн бөгөөд Засгийн газрын бүрэлдэхүүн болон бусад сайд нарын асуудлыг хэлэлцээгүй гэнэ.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ



АН, МАН-ЫН ТОМИЛГОО АРАЙЛ БИШ ЭЭ

Дугаарын 60 мөр

МАН-ынхаан, бүтээн байгуулалтаас татгалзав аа

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Энэхүү төслийг 2015-2020 он хүртэл зургаан жилийн хугацаатай хэрэгжүүлэх юм билээ. Ингэснээр Хүрэл тогоот Монголын “Диснейлэнд” болох боломжтой аж. Гэхдээ “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр хэрэгжиж байгаа цагт шүү дээ. Тиймээс л ядаж энэ хөтөлбөрийг үгүй хийж боломгүй байна. Манай хотод үнэндээ иргэд очоод амраад, зугаалаад, үр хүүхдэд тоглуулах аятайхан газар тун бага. Үндэсний соёл амралтын хүрээлэн байна. Гэхдээ тун дөөхөн тоглоомтой. Үндэсний цэцэрлэгт хүрээлэн одоо бараг л хар зах болчихсон. Дэлхийн хэмжээнд үнэлэгдэх, “Диснейлэнд” шиг газар манайд үнэхээр дутагдаж байна. Тийм болохоор ядаж л энэ мэт бүтээн байгуулалтыг дэмжээд ажилламаар байгаа юм. Ер нь бүтээн байгуулалтаас хэрхэвч татгалзаж болохгүй. Монголын “Диснейлэнд” болох гээд байгаа шинэ Хүрэл тогоот нь зочид утгах цэг, сансрын нисэгчдийн дасгал сургуулиалт болон пуужин хөөргөх, нисдэг онгоцны загвар турших зэрэг талбайтай байх юм гэсэн. Мөн одон орны задгай театрын талбай, одон орон сонирхогчдын кэмп байгуулахаар төсөлд тусгажээ. Үндсэндээ 50 га талбайг цогцолбор болгон тохижуулах төлөвлөгөөтэй байгаа аж. Тэгэхдээ хүүхдүүдийн сонирхлыг татах гол бүс нь пуужин хөөргөх, нисдэг онгоцны загварын туршилтын талбай болох юм байна. Эл талбай нь пуужин хөөргөх тавцан, нисдэг бөмбөлөг, онгоцны загвар турших хэсэг гэсэн бүтэцтэй байна. Пуужин болон загварын нисдэг онгоцны бүтэц хийгүүдийн талаар хүүхдүүдэд мэдлэг олгох зорилгоор АНУ, ОХУ, БНХАУ-ын сансрын хөлөг, нисэх онгоц тэрэгний багасгасан загварыг үзүүлэн байдлаар байрлуулна гэдгээ төсөл хэрэгжүүлэгчид ярьсан байсан. Харин томчуудын зорьж очих талбай бол одон орны задгай театр байх гэнэ. Одон орон судлах оргилын ойролцоох дөвөгт одот тэнгэрийг дурандах дуран суурилуулах юм байна. Эндээс нарны аймгийн гарагууд, сарны гадаргууг дурандахад хамгийн тохиромжтой аж.

Мөн тухайн бүсэд одон орон сонирхогчдод зориулсан музей, үзэсгэлэнгийн танхим зэрэг одон орон судлалыг хөгжүүлэх байгууламжууд байрлах юм байна. Гэх мэтээр маш сайхан төлөвлөгөө гарчихсан байна. Энэ төлөвлөгөөг бодит байдал дээр амилуулах шаардлагатай байна. Тиймээс л “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр хэрэгтэй. Ердөө л наад захын ганц төсөл л ямар их ач холбогдолтой эрх барьж байгаа МАН-ынхан ойлгож байгаа байлгүй дээ. Улаанбаатарчууд бидэнд очоод амарчих, үр хүүхдэд сэтгэл амар тоглуулах газар олноороо нэмэгдэж байвал л сайн байна. Тэгэхийн тулд бүтээн байгуулалт хэрэгтэй. Харин МАН өнгөрсөн дөрвөн жилд эхлээд тавьсан “Бүтээн байгуулалтын хувьсгал”-ыг халамжийн “дайн” болгочихгүй л байх хэрэгтэй байна шүү. Монголд “Диснейлэнд”-ээс эхлээд олон гоё бүтээн байгуулалт хэрэгтэй байна.

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Өнөөдрийг хүртэл толхилцоон бүрээ дотоод ардчилал, эв нэгдэл гэсэн үгээр халхалж ирлээ. Наадмаас өмнө төр засгаа төвхнүүлэх үүрэг Төрийн тэргүүнээс авсан МАН-ынхан томилгоог ар араас нь хийж, томчуудын томилгоо явагдсаар байгаа. Дараа нь доод, дунд шатных эхэлнэ. Энэ намрыг дуустал томилгоо үргэлжлэх нь тодорхой. УИХ-ын даргад намын даргаа томилсноос эхэлж УИХ-ын дэд дарга, намын бүлгийн дарга, Нийслэлийн Засаг даргаа томилчихлоо, тэд, Сөрөг хүчин болсон АН-ынхан юу дутах билээ фракцийн наймаагаар улс төрийн томилгоогоо хийгээд эхэлчихэж. Харамсалтай нь эдгээр томилгоонууд нүдээ олсон, шинэчлэгдсэн гэхээс илүү нүглийн нүдийг гурилгаар хуурсан төдий, хариуцаагаас булгаж нуугдсан, ах дүү амраг садны, фракцийн томилгоо байгаад ард түмэн эгдүүцэж байгааг нуух юун. Тэр тусмаа ард түмэнд сайхан амьдрал өгнө хэмээн гарч ирсэн Ардын намын томилгоо АН-аасаа ч долоон дор байгааг шүүмжлэх хүн бишгүй олон байгаа юм.

М.Энхболд дарга хариуцлагаас зугтав уу

Ялсан намын дарга нь Ерөнхий сайдынхаа ажлыг хийдэг жишиг АН-ыг эрх барьж байх үеэс алдагдсан. Өөрөөр хэлбэл, 2013 онд АН-ынхан Засгийн газраа унагахдаа Ерөнхий сайдаа намын дарга бус хүнээр тавьсан нь өнөөдрийн том ялагдлынх нь эх үндэс байсныг нуух аргагүй. Намын дарга нь алх цохиж, харин Ерөнхий сайдын ажлыг намын нэг гишүүн хийдэг жишгийг МАН-ынхан ч энэ удаа давтлаа. Ялсан намын дарга нь УИХ-ын дарга болж, ямар ч хамаагүй нэг нөхөр Ерөнхий сайд хийх нь тодорхой болов. Магад, М.Энхболд даргад Гүйцэтгэх засаглалыг толгойлж “жижиг” харагдахыг хүсээгүй том амбиц байж мэдэх. Гэвч нөгөө талаас харвал тэр хариуцаагаас зүтгчихлаа. Үүнийг нь нам доторхи туршлагатай гишүүд ч хэлж байсан билээ. УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин УИХ-ын чуулганы танхимаас намын даргадаа хандан “Таныг УИХ-ын даргаар томилогдож байгааг би хувьдаа дэмжихгүй байгаа. “Миний үзсэн, уншсан номонд ялсан намын дарга нь Ерөнхий сайд болдог, сонгуульд амалсан хөтөлбөрөө барьж аваад хэрэгжүүлдэг, фронтын тэргүүн эгнээнд явдаг жишиг бий. Нам дээрээ гаргасан шийдвэр учраас

би хүндэтгэж байна. Ерөнхий сайд л ачааг нь үүрнэ. Ард түмэнд амласан амлалтаасаа ингэж урваж болохгүй. Засгийн газраа туйлын хариуцлагатай хандаж томилох ёстой. Спикер бол спикер. Хурал удирдана. Гол ачааг Засгийн газар үүрнэ шүү. Нэг үгтэй, нэг нүүртэй байх ёстой шүү” хэмээн сануулсан юм. И.Нямдоржийнхатуухан үгэнд ч намын даргаа хариуцлагаас нуугдсанд дургүйцэж буй өнгө аяс цухалзаж байлаа. Монгол Улсын эдийн засаг амаргүй байгаа. Ирэх жилүүдэд ч илбэ шидээр л биш бол бид уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгаа босгох тун ч амаргүй. Тиймдээ ч намын даргын хувиар тэр үүрэх ёстой ачаагаа үүрээд Ерөнхий сайдаа хийгээд зүтгээд үзэх ёстой байв. Даанч тийм зориг гарсангүй. Дөрвөн жилийн дараа болохоос болохгүй хүртэл би зүтгэсэн шүү гээд хэлээд зогсч байвал ард түмэнд “гоё” харагдах байлаа. Гэвч ачир дээрээ тэр ажлын хүндээс зугтаж, биеийн амрыг харж алх тогшиж суухыг л илүүд үзжээ. Хямралт нөхцөл байдал нэг нам амлалт өгчихөөр арилчихгүй гэдгийг М.Энхболд дарга мэдэж буй учраас нэр цэвэр үлдэхийг илүүд үзсэн нь намын гишүүдээс гадна иргэдийн бухимдлыг ч төрүүлж эхэллээ.

Ачааны хүндийг үүрэх Ж.Эрдэнэбат гэж хэн бэ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат, Аймгийн Засаг даргаар “Атрын III” аяныг эхлүүлж байхад ажиллаж байсан гэхээс өөрөөр монголчууд түүний талаар тун ч дулимаг мэдээлэлтэй. УИХ-д хоёр дахь удаагаа сууж буй Ж.Эрдэнэбатын хувьд Монгол Улсын хөгжлийн төлөө гаргасан бодлогыг хэрэгжүүлж, том намын мөрийн хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлж чадах улстөрч мөн үү гэхээр чамлалтай санагдаж буйг нуух юун. Тэр аймгийн Засаг даргын хэмжээний л улстөрч. Өнгөрсөн дөрвөн жилд УИХ-д суухдаа хэсэгхэн хугацаанд Сангийн сайдаар ажилласныг эс тооцвол төрийн суудал түүнд олдож байсан удаагүй. Сангийн сайдаар ажиллахдаа шинэчлэл хийсэн гэж ярьдаг ч улсын төсөв улайчихсан энэ үед түүний шинэчлэл харагдахгүй байгааг нуух юун. Ядахдаа л нам дээрээ цөөн хэдэн хүмүүс удирдаж үзээгүй жул улстөрчид МАН-ынхан улсын хувь заяаг даатгаад орхичихлоо. Харин түүний хажууд хүчтэй сөрөг хүчнийг дөрвөн жил удирдаж байсан С.Бямбацогт илүү жин дарж байсныг намынх нь гишүүд өвөр зуураа

ярилцаж байгаа гэх. Юутай ч өнөөдөр томилгоо УИХ-аар албажиж, Монгол Улсын Ерөнхий сайдын суудал түүний гарт очих нь ээ. Ж.Эрдэнэбатын ганц авах тал нь эдийн засагч. Магад залуу хүний хувиар зоригтой шийдвэр гаргаж, улсын мөнгө санхүүг зөв чиглүүдэд явахыг үгүйсгэхгүй. Гэвч нөгөө талаас харвал тэр өөрийн хүслээр танхимаа бүрдүүлж чадахгүй билээ. Дарга даамал, өөрийг нь энэ албан тушаалд суулгасан хүмүүст төлөх асар их өртэй үлдэнэ. Ах дүү амраг садных нь хүмүүсийг ажилд авах, сайдаар томилох тохироо нэг бүрээ биелүүлж эхэлвэл МАН-ынхны амлаад байдаг мэргэжлийн Засгийн газар лөөлөө болж хувирна. Ө.Энхтүвшин гишүүний хэлсэнчлэн намын амласан мөрийн хөтөлбөр, улс орны хөгжил дэвшил гээд ачааны бүх хүндийг Засгийн газар үүрдэг. УИХ-ын 76 гишүүний зөв буруу баталсан бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хөрсөнд буулгаж ажлыг тэд хийх учиртай. Тиймдээ ч Ж.Эрдэнэбат маргааш хэн байх вэ гэдэг нь ирэх дөрвөн жилд ямархуу байдалтай улс орныг хүлээлгэж өгөхөөс харагдах нь. Монгол Улсын түүхэнд тодоор бичигдэх Ерөнхий сайдын нэг болно, эс бөгөөс улс төрийн утсан хүүхэддэй болж, муу нэр муухай данстай үлдэнэ. Тэр хэн байхаа өөрөө шийдэх учиртай.

Хотын иргэдийн саналыг аваагүй хотын дарга

Нийслэлийн иргэдийн хурлын анхдугаар хуралдаан өчигдөр болж удирдлагуудаа сонголоо. Хоёр ч удаа хойшилсон анхдугаар хуралдаанаар Нийслэлийн Засаг даргаар Су.Батболд, НИТХ-ын даргаар Ц.Сандуй нарыг томиллов. Харамсалтай нь энэ хоёр ч шинэчлэл биш томилгоо. Тэр тусмаа сонгуулийн үеэр төрийн албыг наймаалцах тухай ярьж байсан нэгэнд том итгэл үзүүлснээрээ МАН өчигдөр муухай харагдлаа. 60 тэрбумын наймаа худлаа байгаагүйг хүн бүхэн мэдэж буй. Харамсалтайн хүссэн албандаа очлоо, одоо наймаагаа эхлүүлж, санхүүжилтээ босго гэсэн үүрэг намаас өгсөн мэтээр Иргэдийн хурлын томилгоо харагдсаныг нуух юун. Нийслэлийн Засаг даргын томилгоо ч энэ удаад санасанд хүрч чадсангүй. Хотын хөгжлийг хотын хүн биш хөдөөнөөс сонгогдож байсан “жирийн” улстөрч шийдэх нь. Тэр Э.Бат-Үүлийн дайтай улстөрч биш. Хүслээр болдогсон бол нийслэлийн иргэдийн саналыг үндэслэж нийслэлчүүд өөрсдөө хотын

даргаа сонгодог байхсан. Ядахдаа л хотын иргэдийн саналыг шат шатны сонгуулиар авсан хүнд МАН хотоо даатгаж чадсангүй. Хүнийрхүү сэтгэлээр битгий хандаасай, төрийн албыг төрийн алба болгож, тэрбумын наймаагаа эхлүүлэхгүй ажиллаасай хэмээн залбирахаас өөр сонголтгүй боллоо, бид.

Ардын намаас ялгарах зүйл АН-д ч бас алга

Энэ мэтээр эрх баригч намын томилгоо өнөөх л хуучин хэв загварт баригдсан, том дарга нарынхаа татаас түлхээсээр явагдаж байна. Цаашдаа мэргэжлийн хүмүүс Засгийн газарт орж ажиллана гэсэн итгэл ч алга болж буй. Эх сурвалжуудын хэлж буйгаар худ ургаа, төрсөн дүүгээ, эхнэрийнхээ дүүт сайд болгочих гэсэн том дарга нарын толхилцоон, зөрчил МАН-д хэдийнэ өрнөж эхэлсэн сурагтай. Давхар, дан дээлний тухайд энэ удаад ярих нь ч илүүц биз. Ах намыг ийн албан тушаалын төлөө дээгүүр доогуураа “зодолдож” байх зуур АН-ынхан ч халаа сэлгээг хийж эхлэв. Намын даргаасаа эхлээд доод дунд шат хүртлээ өөрчлөгдөж байна. Ялагдал бүрийн дараа улс төрийн намууд шинэчлэлт хийдэг бичигдээгүй хуулийн дагуу АН-ынхан ч шинэчлэл хийх тухай ярьж эхэлсэн. Гэвч өнөөдрийн томилгоог харахад шинэчлэл гэх хэлээд хэцүүхэн. АН-ын бүлгийг иргэд л “Шонхор” фракци авчихлаа. Уг нь хүн чанар гэж байдаг бол намаа үнэмлэхүй ялагдуулсан энэ фракци хариуцлагаа ухамсарлаад дөрвөн жил дүүгүй суух байлаа. Гэтэл өнөөх л Шонхор, тэр дундаа С.Эрдэнэ Ардчилсан намын шинэчлэл байсан гэж бодохоор эмгэнэлтэй. УИХ-ын даргын томилгоо ч үнэндээ шинэчлэл биш. Аль ч үед албан тушаалтайгаа үлддэг “Алтангадаас” фракцийн томилгоо тэнд хийгдэв. АН-д ганц итгэл найдвар төрүүлж буй томилгоо нь намын даргынх. Өөрөөр хэлбэл, АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж, намаа ялагддаг хүргэж байсан УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатад АН дараагийн дөрвөн жил итгэл хүлээлгэх бололтой. Хэдийгээр одоо түр хариуцаж байгаа ч АН-д үүнээс өөр сонголт байхгүй. Шинэ залууд гэхээс илүү шинэ өнгө төрхөөр намаа удирдаж чадах хүнд л АН итгэхээс өөр аргагүй болжээ. Юутай ч АН-ын шинэчлэл хүлээн зөвшөөрөгдөж чадах эсэхийг өнөөдөр хэлэхэд эрт байгаа ч энэ мэтээр фракцийн томилгоо явагдсаар байвал шинэчлэлийн тухай ярих хэрэг байхгүй билээ.



ОЮУНЛАГ БАГАЧУУД
Ц Э Ц Э Р Л Э Г

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД УРЬЖ БАЙНА
Байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэжил, мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

Нийтлэг шаардлага:
Боловсрол: Боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил: Сургуулийн өмнөх боловсролын багш
Мэргэшил: СӨБ, Боловсролын менежмент
Туршлага:
 - Боловсролын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх
 - Багшлах болон боловсролын удирдлагаар хосолсон дадлага туршлагатай байх
 - Боловсрол, удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх

Ур чадвар:
 - Стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх
 - Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй
 - Мэдээлэл боловсруулах
 - Асуудал шийдвэрлэх
 - Судалгаа шинжилгээ хийх
 - Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглах
 - Бусдыг манлайлах
 - Багаар ажиллах
 - Ёс зүйн болон харилцааны соёлтой байх

АХЛАХ ТОГООЧ

Нийтлэг шаардлага:
Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
Мэргэжил: Хоол үйлдвэрлэл, хүнсний технологи болон нийтийн хоолны технологи мэргэжлээр төгссөн
Мэргэшил: Нийтийн хоолны чиглэлээр мэргэшсэн
Туршлага:
 - Сургууль болон цэцэрлэгт нийтийн (хүүхдийн) хоолны чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан
 - Тогоочийн зэрэгтэй, ахлах тогооч болон тогоочоор ажиллаж байсан туршлагатай байх
 - Сургууль, цэцэрлэгийн тогооч нарын сургалтад хамрагдсан байх

Ур чадвар:
 - Бусадтай хамтран ажиллах чадвартай
 - Бүтээлч сэтгэлгээтэй байх
 -Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглах
 - Бусдыг манлайлах
 - Багаар ажиллах
 - Ёс зүйн болон харилцааны соёлтой байх
Тусгай шаардлага:
 Сургууль, цэцэрлэгийн хэв шинж онцлогийн талаар зохих мэдлэг, туршлагатай байх

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. Боловсролын дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар
2. Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
3. Ажил байдлын тодорхойлолт
4. Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
5. 3x4 хэмжээтэй 2% зураг
6. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн өргөдөл
7. Тухайн байгууллагыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр
8. Боловсрол, удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг нотлох диплом, сертификатын баталгаажуулсан хуулбар эсвэл эх хувь

Жич: Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй болон холбогдох материалыг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 11-р хороо, Их монгол улсын гудамж, “Deluxe marshall village” хотхон, King tower apartment 1-4 байрны Lobby танхимд

Бүртгэлийн хугацаа: 2016 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 18.00 цаг хүртэл бүртгэнэ.

☎ 77002024, 89682233

🌐 www.mongoloyun.mn

ЦАГ ҮЕ

МОНГОЛД ҮЙЛДВЭРЛЭВ

МОНГОЛ ГЭР, ОДОН ЭДЛЭЛ ДЭЛХИЙД ҮНЭЛЭГДЖЭЭ

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Тодруулбал, өнгөрөгч зургадугаар сарын 25, 26-ны өдрүүдэд ХБНГУ-ын Франкфурт хотноо болсон олон улсын аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн дундах шилдгүүдийг тодруулдаг "International Arch of Europe Award" ёслолын ажиллагаанд Монголыг төлөөлж, "Woodman" ХХК оролцож, "International Arch of Europe in the Gold Category" буюу олон улсын чанарын алтан цомын эзэн болсон бахдам амжилт гаргасан байна. 29 дэх жилдээ зохион байгуулагдаж буй энэхүү олон улсын томоохон уралдааны нэр хүндтэй шагналыг монгол компани хүртсэн нь манай үйлдвэрлэгчид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Азийн орнууд цаашлаад чанар стандартыг дээд эргээр шаарддаг буурал тивд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд бэлэн болжээ гэдгийг харуулсан үйл явдал боллоо. Өмнө хэлсэнчлэн, дотоодын жижигхэн зах зээлээр хязгаарлагдаж байсан үндэсний үйлдвэрлэл дэлхийн зах зээлд гарахад бэлэн болсныг энэхүү үйл явдал харуулсан гэхэд болно. "International Arch of Europe" арга хэмжээнд 40 гаруй улсын 70 гаруй нэр хүндтэй шилдэг байгууллагууд оролцжээ. Нэр хүнд, оролцогчдын цар хүрээгээрээ дэлхийд хэдийнэ танигдсан энэхүү уралдааны өмнө жилийн шилдгүүдээр олон улсын банк санхүүгийн байгууллагын төлөөлөл ING group, ALCOA групп, WalMart зэрэг нэр хүндтэй байгууллагууд шалгарч байсан аж. "Вүүдман" компани нь Монгол Улсаас анх удаа хүндтэй шагналын эзэн болсон юм байна. Дотоодын зах зээлд өөрийн гэсэн үйлчлүүлэгчтэй болж, чанар стандартгаар өөрийн нэр хүндийг модмодон үйлдвэрлэлийн салбарт дархалж орхисон тус компани монгол гэрээс гадна, модон сандал ширээ, гэрийн тавилга, орон сууцны модон хаалга, цонх, ханын стейк, гал тогооны тавилга гээд модоор хийж болох бүх л бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн



захиаг, таашалд нийцүүлэн үйлдвэрлэдэг байна. Түүнчлэн ойн сан дахь хаягдал модыг ашиглаж бүтээгдэхүүнээ хийдэг учраас ойн санг устгах гэхээс илүү байгаль экологийн хувьд давуу талтай аж. Жилд дунджаар 10 мянган айлын орон сууц, үйлчилгээний барилга шинээр ашиглагдаж орж, үүнийг дагаад хаалга, цонх, тавилгын хэрэгцээ нэмэгдэж, энэ төрлийн үйлдвэрлэгчид чадавхижиж байгаа юм. 2007 оноос аж ахуйн нэгжүүд дотооддоо модон хавтан үйлдвэрлэх технологи нэвтрүүлж, өнөөдрийн байдлаар жилд 12 мянган шоо метр хавтан үйлдвэрлэх хүчин чадалтай нэг, 500 шоо метр хавтан үйлдвэрлэдэг 10 гаруй компанитай болсон бол 10 орчим иргэн, аж ахуйн нэгж 5500 шоо метр хавтан урд хөршөөс импортлож байгаа гэсэн тоон мэдээ бий. Хэрэв дотоодын зах зээлээ хамгаалж чадвал манай үйлдвэрлэгчид эх орны хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй 10 гаруй тэрбум төгрөгийн хавтан экспортлох боломжтой гэсэн судалгааг Аж үйлдвэрийн яамнаас танилцуулж байсан удаатай.

"Вүүдман" компанийн Гүйцэтгэх захирал М.Чинзоригтой бид компанийнх нь талаар болон модон эдлэлийн үйлдвэрлэлийн талаар цөөн хором ярилцлаа.

М.Чинзориг: Бид хэрэглэгчийнхээ хүсэл таашалд нийцсэн бүх модон эдлэлийг үйлдвэрлэдэг

-Олон улсын энэхүү нэр хүндтэй шагнал Монгол Улсын хувьд ямархуу үнэ хүнд дагуулж ирээ?

-Олон улсын 40 гаруй орны 70 гаруй компани оролцсон том уралдаан. Алтан цомыг нь манай компани авлаа. Монголын модон үйлдвэрлэлийн салбар чанарын өндөр төвшинд хүрснийг илтгэж байгаа.

-Хэчнээн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна?

-Модоор хийж болох бүх л бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилго тавиад ажиллаж байна. Монгол гэр, албан тасалгааны

тавилга, модон байшингийн бэлдэг, ханын стейк гээд олон байна.

-Модон эдлэлийг өнгөлөөд шууд лак түрхдэг юм байна. Лакаа хаанаас оруулж ирдэг вэ?

-Манай Солонгос болон ОХУ-ын бүтээгдэхүүн ашигладаг. Сүүлийн үед усан суурьтай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй экологийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглэхийг зорьдог болсон. Мод тайрч бэлтгээд бэлэн бүтээгдэхүүн болсон ч тухайн орчиндоо экологийн нөлөө үзүүлж байдаг. Хүүхдийн өрөө, унлагын өрөө, удаан байдаг албан тасалгааны тавилгыг модон байх нь зүгээр байдаг. Модон бүтээгдэхүүний үнэ боломжийн байдаг учраас түгээмэл хэрэглэдэг.

-Монгол гэрийн тухайд хэдэн төгрөгийн үнэтэй байдаг бол?

-Таван ханатай гэрээс эхлээд 20-80 сая төгрөгөөр зарагддаг. Хүй долоон худагт наадам болоход манай гэрийг хүмүүс илүү их хэрэглэх хандлагатай байдаг. Манайх сүүлийн үеийн

модерн хэв маягийг оруулаад, дотоод зохион байгуулалт хүний хэрэглээнд илүүтэй анхаардаг болсон. Биеийн харьцаа, ор, шкафын өндрийг хүртэл харгалзаж үздэг.

-Монгол гэрийг дэлхий дахин сонирхдог болсон байна. Олон улсад бүтээгдэхүүнээ худалдах бодол байна уу?

-Манай улсын түүхийг сонирхож байгаа хувь хүмүүс олон болсон. Судлаачид өөрсдийн сонирхлоор их захиалдаг. Мөн өөр орчинд өөрөөр хэлбэл, гэрт хурим хийхийг хүсдэг болсон байна. Гаднаас захиалга их ирдэг. Хэзэ угалзтай, сийлбэртэй гэхээс илүү орчин үеийн хэв маягийг илүүтэй сонирхдог. Гэрийг тээвэрлэхэд амар хялбар, хаана ч тээвэрлэх боломжтой гэдэг утгаараа худалдаж авахыг хүсдэг.

-Танай компанийн бүтээгдэхүүн хаагуур зарагддаг вэ?

"Мишээл экспо" төвийн В-5 павильноос гадна, Урт цагаанд борлуулдаг. Мөн үйлдвэр дээрээ захиалга авч борлуулалт хийдэг.

-Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих талаар төрийн бодлого хэр зөв явж байна вэ?

-Бид ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо гэж байгуулаад явж байгаа. Тус холбоог байгуулснаас хойш дуу хоолойгоо нэгтгэж, өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалах талаар дуугарах болсон. Модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгчид бүгд хамрагддаг. Бид өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж ажиллах цаг нь болсон. Хоёр жилийн өмнө тухайлбал төрийн бодлого хангалттай байгаагүй. Улс бодлогоор дэмжээд өгвөл хувийн хэвшил үсрэлтгүй хөгжих боломжтой. Импортын модон эдлэлд татвар өндөр тогтоож өгсөн ч үр дүн хараахан гараагүй байна. Гадагшаа гарах зах зээлд модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгч компаниуд нэгдээд гарах боломжтой гэж ярилцаж байгаа. Дотооддоо мэдээж бид өрсөлдөгчид. Харин гадны зах зээлд бид хамтарч л гарах боломжтой. Олон жижиж компаниуд байгаа учраас дангаараа гарах хэцүү л дээ.

АЯН ЗАМД ГАРАХЫН ӨМНӨ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙНХЭЭ БҮРЭН БҮТЭН БАЙДАЛД АНХААРАЛ ХАНДУУЛААРАЙ

Баяр наадмын өдрүүдээр олон хоног амарч, хөдөө орон нутагт аялах зорчигч тээврийн урсгал нэмэгдэж буйтай холбогдуулан Автотээврийн үндэсний төвөөс нийт тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд хандан аян замд гарахын өмнө эрхэм жолооч таныг өөрийн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарал тавьж, аюулгүй тээврийн баталгааг хангаж зорчихыг зөвлөж байна.

Мөн 2016 оны эхний зургаан сарын байдлаар улсын хэмжээнд зам тээврийн осол 193 бүртгэгдсэний 138 нь орон нутгийн замд гарч 43 хүн нас барсан байна. Үүний ихэнх хувийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон болон тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаагүйгээс шалтгаалсан осол эзэлж байгаа тул эрхэм жолооч, иргэд та бүхнийг архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ орон нутгийн замд гарахгүй байхыг анхааруулж байна.

Автотээврийн үндэсний төвийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн олон жилийн дадлага туршлагатай мэргэшсэн инженер, техникийн ажилтнуудаас бүрдсэн мэргэжлийн хамт олон дараах цагийн хуваарийн дагуу танд үйлчилж төмөр хүлгийн тань талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллана.

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Үүнд:

- 2016 оны долдугаар сарын 10-ны өдрийг дуустал ажлын өдрүүдэд 08:30-20:30, амралтын өдрүүдэд 09:00-19:00 цагийн хооронд уртасгасан цагийн хуваариар ажиллана.
- 2016 оны долдугаар сарын 16, 17-ны өдрүүдэд "Да Хүрээ Трейд" техникийн худалдааны төв дэх тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын явуулын үзлэг хэвийн цагийн хуваарийн дагуу ажиллана.
- Бусад салбарууд 2016 оны долдугаар сарын 11-17-ны өдрүүдэд амарна.
- 2016 оны долдугаар сарын 18-ны өдрөөс эхлэн уртасгасан цагийн хуваариар буюу ажлын өдрүүдэд 08:30-20:30 цагийн хооронд, амралтын өдрүүдэд 09:00-19:00 цагийн хооронд ажиллана.

ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: 10-р хороолол 6/0.4 кв-ийн 2*630 кВа чадалтай хаалттай дэд өргөө шугамыг орон нутгийн өмчид авах

Тендер шалгаруулалтын дугаар: OP-167/2016
Огноо: 2016-07-04 өдөр

Орхон аймгийн ЗДТГ эрх бүхий тендэрт оролцогчдоос 10-р хороолол 6/0.4 кв-ийн 2*630 кВа чадалтай хаалттай дэд өргөө шугамыг орон нутгийн өмчид авах тухай ЦАХИМ тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.meps.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу. Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг үзсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендэрт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
 - Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх
 - 2014, 2015 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтын хамт ирүүлэх
 - Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Худалдаа үйлчилгээний чиглэлээр ажилласан туршлагатай байх
- Тендэрт оролцогч нь санал болгож буй үнийн дүнгийн 2%-наас багагүй төгрөгийн дүнтэй тендерийн баталгааг цахимаар гаргаж ирүүлнэ. Тендерийг 2016 оны 07-р сарын 19-ны өдрийн 14 цаг 00 минутаас өмнө www.meps.gov.mn хаягаар цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендэрт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07-р сарын 19-ны 14 цаг 30 минутад нээнэ. Гадаадын этгээд тендэрт оролцох эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно. Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны алба
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас: 70358570

МЭДЭЭЛЭЛ

САЙД ЯРЬЖ БАЙНА

Л.ПҮРЭВСҮРЭН: АСЕМ-Д 34 ОРНЫ ТӨР ЗАСГИЙН УДИРДЛАГА ИРЭХЭЭ МЭДЭГДСЭН

-АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад хэчнээн орны төр засгийн тэргүүн хүрэлцэн ирэхээр болсон бэ. Мөн зочид төлөөлөгчид хэзээ ирэх бол?

-Одоогийн байдлаар дээд хэмжээний уулзалтад 34 орны төр засгийн удирдлагууд оролцохоор нотолгоогоо өгөөд байна. Үүнийг ерөнхийлөгч, ерөнхий сайд нарын хэмжээнд гэж ойлгох учиртай. Монгол Улсын хувьд өмнө нь олон улсын төрийн тэргүүнүүдийг нэг дор хүлээж авч байгаагүй гэдэг утгаараа өндөр ач холбогдолтой. Бусад нь гадаад хэргийн сайд, тусгай элчийн төвшинд оролцож байна. Зочид энэ сарын 12, 13, 14-ний өдрүүдэд ирнэ. Ирж буй зочдоос 4-5 улсын ерөнхийлөгч, ерөнхий сайд нар Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ. Тиймээс 13-наас эхлээд хоёр талын айлчлалаа хийгээд эхэлнэ. Сингапурын ерөнхий сайд 14-ний өдөр Монгол Улсад айлчлалаа эхлүүлнэ. Вьетнамын ерөнхий сайд 13-нд ирнэ. Энэ мэтчилэн бусад төвшиний айлчлалууд бий.

-34 орны төрийн тэргүүн ирнэ гэлээ. Энэ тоо цаашид нэмэгдэх үү. Мөн урьдчилсан байдлаар хэчнээн жуулчин ирэх тооцоо бий вэ?

-Зарим улсад сонгууль болсон, нөгөө хэсэгт болох гэж байна. Иймэрхүү ноцол байдлаас үүдээд ирэх хүмүүсийн нэр өөрчлөгдөх зэрэг асуудал байна. Энэ тоо цаашид өсөх эсэхийг мэдэхгүй байна. Ямартай ч 51 орон, хоёр олон улсын байгууллага бүрэн төлөөлөлтэй ирнэ. Европын холбооноос л гэхэд ерөнхийлөгч, зөвлөлийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч бөгөөд гадаад харилцаа хариуцсан тусгай төлөөлөгч гээд гурван дарга ирнэ. Одоогоор 500 гаруй гадны сэтгүүлчдийн бүртгэл хийгдсэн.

Ц.СОЛОНГО

АСЕМ-ын дээд хэмжээний уулзалттай холбоотойгоор Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн өчигдөр мэдээлэл өгсөн юм. Энэ үеэр зарим асуултад харуулт авлаа.

...Мөн Улаанбаатар хотын шинэ дарга томилогдож байна. Шинэ даргатайгаа хамтарч ажиллана. Ялангуяа Чингисийн хүрээнд болох Монгол наадам арга хэмжээг нийслэл хариуцаж байгаа. 2000 орчим хүний хүлээн авалт хийнэ. Тиймээс ажил цалгардуулахгүй явах байх гэж бодож байна...

Энэ тоо ойрын үед нэмэгдэнэ. Тэдэнд Монголыг зөв талаас нь таниулах, монгол ахуй, наадам, соёл, орчин үе, улс төр, эдийн засгийн байдлаа зөв ойлгуулах нь нэн чухал. Тиймээс энэ тал дээр Гадаад хэргийн яам сүүлийн жилүүдэд идэвхтэй ажилласан.

-Олон орны төрийн тэргүүн Монгол Улсад анх удаа айлчилж байна. Ялангуяа анх удаа ирж байгаа Сингапур, Вьетнамын төрийн тэргүүнүүдтэй ямар

яриа хэлэлцээр хийх вэ. Хоёрдугаарт, Засгийн газар солигдож байна. Тэгэхээр АСЕМ-ыг зохион байгуулах ажил дараагийн Засгийн газарт шилжинэ гэсэн үг үү?

-Төр залгамж чанараа хадгалж ажиллах ёстой. Бидний хувьд АСЕМ-ын ажлыг сүүлчийн мөч хүртэл хийнэ. АСЕМ-аас өмнө сайд нар солигдох эсэхийг МАН-ын хүмүүсээс асуусан дээр болов уу. Ямар ч байсан шинэ Ерөнхий сайдын нэр тодорч байх шиг байна. Тэгэхээр шинэ Ерөнхий сайд ойрын үе ажилдаа ороод удирдаад чиглүүлээд явна байх. Учир нь Ерөнхий сайдын ахалсан үндэсний хороо ажилладаг. Манай яаманд АСЕМ-ын бэлтгэл ажлын алба бий. Тиймээс бид энэ ажлыг цалгардуулахгүй АСЕМ-аа амжилттай зохион байгуулахад яамны зүгээс бүх хүчээ чиглүүлнэ. Мөн Улаанбаатар хотын шинэ дарга томилогдож байна. Шинэ даргатайгаа хамтарч ажиллана. Ялангуяа Чингисийн хүрээнд болох Монгол наадам арга хэмжээг нийслэл хариуцаж байгаа. 2000 орчим хүний хүлээн авалт хийнэ. Тиймээс ажил цалгардуулахгүй явах байх гэж бодож байна. Мөн Вьетнам улс бол Азийн шинэ баруудын нэг шүү дээ. Манай уламжлалт түнш орон. Сүүлийн үед харилцаа өргөжиж байгаа. Айлчлалын үеэр олон чухал асуудал яригдана. Тухайлбал, манай соёлын өвтэй холбоотой, сэргээн засварлах, эдийн засгийн харилцаа, мах



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

гаргахаас эхлээд олон асуудал ярина. Сингапур Улсын хувьд АСЕМ-ын гол орны нэг. Энэ утгаараа бид Сингапуртай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх талаар ярьж байгаа. Визний хувьд харилцан адил байхаар тохирсон шинэ тохиролцоонд гарын үсэг зурна. Мөн Монгол Улсад 140 гаруй төрийн өмчийн компаниуд хувьчлагдаагүй байна. Бид чөлөөт зах зээл рүү орлоо гэсэн. Гэтэл үндсэндээ дутуу хийсэн зүйл байна. Энэ нь эргээд Засгийн газар солигдохоор хамаатан саднуудаа томилдог, хүмүүсийг солих гэх мэтээр улсын мөнгийг үрэн гаран хийдэг болчихоод байгаа. Энхийг өөрчлөн шинэчилж, улс төрөөс хараат бус, цэвэр зах зээлийн зарчмаар явуулдаг тогтолцоог Сингапур улс амжилттай хийсэн байдаг. Үүнийг оруулж ирэх талаар Монгол Улсын Ерөнхийлөгч

гурван жилийн өмнө Сингапурт айлчилж тодорхой ажил хийсэн. Хуулийн төсөл бэлэн болсон. Үүнийг шинэ Засгийн газар дэмжиж, ажил хэрэг болгоно гэж харж байна. Мөн орон сууцны хөтөлбөрийн чиглэлээр хамтарч ажиллах, гарын үсэг зурах асуудал бий. Үүнээс гадна БНСУ-ын ерөнхийлөгч Пак Гын Хэ АСЕМ-д оролцоод, төгсгөлд нь Монголд албан ёсны айлчлал хийнэ. Энэ үеэр БНСУ-тай олон баримт бичигт гарын үсэг зурахаар бэлтгэж байна.

-БНСУ-ын айлчлалын үеэр манай талаас ямар санал боловсруулсан бэ?

-Монгол Улсын Ерөнхийлөгч тавдугаар сарын сүүлчээр БНСУ-д албан ёсны айлчлал хийсэн. Эргээд ойрын хугацаанд БНСУ-ын талаас албан ёсны айлчлал

хийх гэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хийсэн яриа хэлэлцээрийг үргэлжлүүлнэ. Мөн БНСУ-ын зүгээс амласан 300 сая ам.долларын тусламж бий. Үүнд нэлээд олон төслийн хэлэлцээр явагдана. АСЕМ-д зориулаад орчин үеийн автобусыг зээлээр олгож байгаа. Автобусыг түрүүлж аваад заримыг нь хэрэглэж байна.

-АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын өмнө есөн дагалдах хурал болох учиртай. Хурлууд хэр явж байна?

-АСЕМ байгуулагдаад 20 жил болж байна. Түүхэн ойтой давхцаж буй энэ удаагийн дээд хэмжээний уулзалтыг "Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө" гэсэн сэдвээр зохиож байгаа. АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтын өмнө есөн дагалдах хурал болно. Одоогоор дөрвөн арга хэмжээ зохиож дууссан. Тав дахь нь үргэлжилж байна. "Ази-Европын түмний чуулган" буюу төрийн бус байгууллагуудын чуулган уржигдар эхэлж, өнөөдөр дуусна. Энэ чуулганд 500 гаруй төлөөлөгч оролцож байна. "Ази-Европын эв санааны шинэ нэгдлийг цогцлоон эрх тэгш шударга хүртээмжтэй хөгжлийн арга замыг илэрхийлэх хөгжихгүй" гэсэн сэдэвтэй. Монгол Улсаас Улаанбаатар хотын төлөөлөл 114 хүн, орон нутгийн 184 хүн, гадны 50 гаруй улсын 214 хүн оролцож байна. Төрийн зүгээс зохион байгуулах бүх талын дэмжлэг үзүүлж байгаа. Агуулгад нь оролцохгүй гэдгээрээ Монгол Улс ардчилсан орон гэдгээ харуулж буй. Нийтдээ найман сэдвээр үргэлжилж байна. Мөн АСЕМ-ын залуучуудын чуулга уулзалт үргэлжилж байна. Уг уулзалт энэ сарын 6-10-ны өдрүүдэд үргэлжинэ. Монголын талаас шилдэг 50 залуу, гаднаас 51 орны шилдэг 100 залуу оролцож байна. Монголын талын 50 шилдэг залууг сонгох ажлыг Монголын залуучуудын холбооноос хийсэн. Мөн энэ сарын 7-8-нд Редакторуудын дутуй ширээний 8 дугаар уулзалт, 12-14-нд АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт, 13-14-нд Ази, Европын Бизнесийн 15 дугаар чуулга уулзалт болно.

АСЕМ-11

ТҮМНИЙ ЧУУЛГАН ӨНДӨРЛӨЖ, ЗАЛУУСЫН ЧУУЛГАН ЭХЭЛЛЭЭ

Ж.МЯГМАР

“Ази-Европын эв санааны шинэ нэгдлийг цогцлоон, эрх тэгш, шударга, хүртээмжтэй хөгжлийн арга замыг эрэлхийлэн хөгжүүлэхүй” сэдвийн дор болсон “Ази, Европ түмний 11 дүгээр чуулган” өчигдөр хаалтаа хийлээ. АСЕМ-ын Дээд төвшний 11 дүгээр уулзалтын дагалдах хурлуудын нэг болох энэхүү хуралд 42 орны 750 төлөөлөгч оролцлоо. Хоёр тивийн орнуудын ард иргэдийн уялдаа холбоог бэхжүүлэх, хүсэл эрмэлзлийг АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад хүргэх зорилго бүхий “Ази, Европ түмний 11 дүгээр чуулган” үүргээ амжилттай биелүүллээ гэдгийг Зохион байгуулах хорооны дарга Л.Төр-Од хаалтын үеэр хэлсэн үгэндээ онцлолоо.

Тэрбээр, “АСЕМ-ын 20 жилийн босгон дээр Монгол Улс хоёр тивийг холбож, улс орнуудын



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ард түмний идэвх, санаачилгаас харилцан суралцах, туулсан замын сургамжаас хуваалцахад түүхэн үүрэг гүйцэтгэлээ.

Монгол Улс Мянганы хөгжлийн IX зорилт буюу Ардчилсан засаг, хүний эрх, авилгагүй нийгмийг

тодорхойлон хэрэгжүүлсэн нь эдүгээ 2030 он хүртэл хэрэгжих замын сургамжаас хуваалцахад түүхэн үүрэг гүйцэтгэлээ. Тиймээс Монгол Улс энэхүү үзлийг Ази, Европ төдийгүй дэлхий нийтэд үлгэрлэн

манлайлах үүрэгтэй. Энэхүү үүргээ хэрэгжүүлж, Ази, Европын Түмний чуулганыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн ГХЯ, АСЕМ-ын ажлын албаныхан болон бусад албаны хүмүүст талархал илэрхийлж хэмээв.

Энэхүү түмний чуулганаар байгалийн нөөцийн шударга хуваарилалт, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний тогтвортой үйлдвэрлэл, худалдаа болон хөрөнгө оруулалтыг шударга болгох стратеги, оролцоот ардчилал, цөөнхийн эрх, хүйсийн эрх тэгш байдал, терроризмд өгөх хариу зэрэг 8 гол асуудлын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлжээ. Хуралдааны төгсгөлд Тунхаглал гаргасан бөгөөд өнөөдөр АСЕМ-ын мэдээллийн төвд дэлгэрэнгүй мэдээлэл хийх юм байна. Ийнхүү түмний чуулган ёслол төгөлдөр хааж, АСЕМ-ын дээд төвшний 11 дүгээр уулзалтын дагалдах хурлуудын нэг болох “АСЕМ-ын Залуучуудын чуулган” өчигдөр эхэллээ. Энэхүү чуулган долдугаар сарын 6-10-ны өдрүүдэд үргэлжилнэ. Дөрвөн өдөр үргэлжлэх уг чуулганд АСЕМ-ын гишүүн 51 орны 100 төлөөлөгч,

Монголын шилдэг 50 залуу оролцох юм байна.

Олон улсын төлөөлөгчдийн хувьд 3000 гаруй залуусаас шигшигдсэн манлайлагчид гэдгийг зохион байгуулагчид онцолсон юм. Залуус энэ удаад улс төр, эдийн засаг, нийгэм, соёл урлаг гэсэн үндсэн дөрвөн сэдвээр өөрсдөд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, шийдлийг хайх юм байна. Ингээд тодорхой үр дүнд хүрч, түүнийгээ АСЕМ-ын дээд төвшний уулзалтад гаргаж тавих учиртай. Монголыг зорин ирсэн залууст түүх соёл, эртний монголчуудын аж амьдралын түүхээссонирхуулахаархөтөлбөрт тусгажээ. Мөн Чингис хааны хөшөө дурсгал, Цонжин болдог гээд түүх, соёлын олон газрыг сонирхуулахаар төлөвлөсөн байна. Үүгээр ч зогсохгүй орчин үеийн монгол залуусын хэв маягтай танилцуулах төлөвлөгөөг ч хөтөлбөртөө багтаажээ.

ALBAN ESCOOP PC mall - Д ИРЛЭЭ

ASUS ROG G-SERIES

REPUBLIC OF GAMERS

THE CHOICE OF CHAMPIONS

ALBAN ESCOOP PC mall - Д ИРЛЭЭ

ДЭЛХИЙ

Б.ДАВААХҮҮ

Их Британи Европын холбооноос гарах эсэх талаархи бүх нийтийн санал асуулга өнгөрсөн сарын 23-ны өдөр тус улс даяар зохион байгуулагдсан билээ. Улмаар эцсийн дүнгээр британичуудын дийлэнх нь гарах сонголтыг хийсэн байдаг. Гэвч ЕХ-нд тусгай статустайгаар үлдэх тохироог аль эрт хийсэн байсан эрх баригч Консерватив намын тэргүүн Дэвид Камерон санал асуулгын дүнтэй холбоотойгоор Ерөнхий сайдын суудлаасаа ирэх аравдугаар сард буухаа зарласан юм. Түүний гэнэтийн мэдэгдлээс хойш тус улсын дараагийн Ерөнхий сайд хэн байх нь дэлхий нийтийн анхаарлыг татаж эхэлсэн. Бүх нийтийн санал асуулгын хүрээнд гарах болон үлдэх гэсэн сонголтын аль нэгийг хийхийг ард иргэддээ уриалсан улс төрийн хүчнүүдийн кампанит ажил үндсэндээ дөрвөн сарын хугацаанд үргэлжилсэн бөгөөд эрх баригч Консерватив намын гишүүд дотроо ч өөр өөр үзэл бодолтой хүмүүс байсан юм.

...Батлан

хамгаалахын сайд асан Лиам Фокс энэ удаагийн өрсөлдөөнд бүдэрч, мөн бага санал авсан Стивен Крабб нэрээ татжээ. Доод танхимын гишүүдийн саналаар хүчтэй хоёр эмэгтэй өрсөлдөгч Тереза Мэй, Андреа Лидсом нартай Хууль зүйн сайд Майкл Гове тунаж үлдсэн юм...

Гэвч иргэдийнх нь ихэнх нь Европын холбооноос гарах сонголтыг хийсэн тул дараагийн Ерөнхий сайдад мөнлүгшдвэрийг дэмжиж байсан улстөрч дэвших нь гарцаагүй болсон. Улмаар гадаад төрх байдлаараа АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамптай адилхан гэгддэг Борис Жонсон Ерөнхий сайд болох хамгийн өндөр магадлалтай хүн болсон байдаг. Гэхдээ улс төрийн туршлага, намба байхгүй гэх шалтгаанаар зарим нам нэгтгүүдээсээ шүүмжлэл сонсдог байсан тэрбээр өөрөө нэрээ татсан юм. Дэвид Камероны албыг залгамжлах нэр дэвшигчдийн тооноос Борис Жонсон хасагдсанаар нийт таван хүн өрсөлдөж байсан. Тэгвэл тэдний эхний өрсөлдөөн гэх хэлж болохуйц Их Британийн парламентын 330 гишүүний дундах санал хураалт очигдөр болж, Дотоод хэргийн сайд Тереза



ИХ БРИТАНИЙН ЕРӨНХИЙ САЙДАД ГОРИЛОГЧИД

Мэй хамгийн олон санал авчээ. Бүх нийтийн санал асуулгаас өмнө Тереза Мэй Дэвид Камероны нэгэн адил "Үлдэх" сонголт хийхийг дэмжиж байсан ч, иргэд нь нэгэнт шийдвэрээ гаргасны дараа ЕХ-ноос "Гарах" ажлыг тэргүүлнэ гэдгээ илэрхийлсэн байдаг.

Түүний хувьд доод танхимын гишүүдийн 165-ынх нь саналыг авсан байна. Харин олон улсын ажиглагчид хийгээд Британийн улс төр судлаачдын таамагт ч багтаагүй "Битүү морь" гэж хэлж болох Эрчим хүчний сайд Андреа Лидсом 66 хүний саналаар хоёрдугаарт гишгэжээ. Гэхдээ тэдний хоорондын саналын зөрүү асар их байсан юм. Түүнчлэн таван нэр дэвшигчээс хамгийн бага санал авсан Батлан хамгаалахын сайд асан Лиам Фокс энэ удаагийн өрсөлдөөнд бүдэрч, мөн бага санал авсан Стивен Крабб нэрээ татжээ. Доод танхимын гишүүдийн саналаар хүчтэй хоёр эмэгтэй өрсөлдөгч Тереза Мэй, Андреа Лидсом нартай Хууль зүйн сайд Майкл Гове тунаж үлдсэн юм. Парламентын гишүүд өнөөдөр мөн хуралдахаар төлөвлөөд байна. Өнөөдөр болох санал хураалтад дээрх гурван нэр дэвшигчийн хамгийн их санал авсан хоёр нь үлдэж, дараагийн шатны даваа болох намын гишүүдийн хурлаар батлуулах учиртай. Тодруулбал, Консерватив намын 150 мянган гишүүний дунд санал хураалт явуулах бөгөөд эцэст нь Дэвид Камероныг залгамжлагч есдүгээр

сарын 9-нд тодрох билээ.

ТЕРЕЗА МЭЙ ГЭЖ ХЭН БЭ

Тереза Мэй дараагийн Ерөнхий сайдад яг тохирох хүн хэмээн намынхан нь үнэлдэг ажээ. Түүний хувьд намыг хагаралдуулсан бүх нийтийн санал асуулгын үеэр ЕХ-нд үлдэхийг дэмжиж байсан ч, ямар нэг хурц мэдэгдлийг хийж байгаагүй бөгөөд хоёр талд хуваагдсан улстөрчдийг зохицуулах үүрэг гүйцэтгэж, нэгтгэхийг эрмэлзэж байсан нь Ерөнхий сайд болоход хамгийн тохирох хүн гэх дүгнэлтийг хийхэд хүргэсэн гэх. Тереза Мэй 2010 оны бүх нийтийн сонгуульд Консерватив нам ялалт байгуулсны дараа Дотоод хэргийн сайдаар томилогдон, Дэвид Камероны Засгийн газарт орж ажилласан байдаг. Улмаар 2015 оны сонгуулиар ч гэсэн Дотоод хэргийн сайдаар улиран томилогдож, цагаачдын эсрэг хатуу бодлого баримтлах болсон юм. Түүний тууштай зан чанар, гадаад төрх 1980 оны тус улсын Ерөнхий сайд Маргарет Тэтчерийг санагдуулдаг хэмээн хүмүүс үнэлдэг байна. Тэрбээр намынхныхаа дэмжлэгийг хүлээж чадвал Маргарет Тэтчерийн дараах Их Британийн хоёр дахь эмэгтэй Ерөнхий сайд болох юм.

"БИТҮҮ МОРЬ" АНДРЕА ЛИДСОМ ГЭЖ ХЭН БЭ

Улс төр судлаачид, олон улсын

ажиглагчдын хэнийх нь ч таамагт багтаагүй "Битүү морь" гэж нэрлээд буй Эрчим хүчний сайд Андреа Лидсом парламентын гишүүдийн 66-ынх нь дэмжлэгийг авсан. Олон улсын хэвлэлүүд Тереза Мэйг Ерөнхий сайд болох магадлал өндөртэй хэмээн дамжуулж, түүний хүчтэй өрсөлдөгчийн тоонд Хууль зүйн сайд Майкл Гову нэрлэж байсан билээ. Гэсэн ч, парламентын гишүүдийн дунд болсон санал хураалтад Андреа Лидсом түүнийг ардаар орхиж, чансаагаараа хоёрдугаарт бичигдсэн. Их Британийн Европын холбооноос гарах эсэх талаарх санал асуулгад Андреа Лидсом "гарах" гэсэн байр суурийг баримталж байсан юм. Тиймээс ч, 150 мянган консервантчууд дундаас "гарах"-ыг дэмжиж байсан гишүүд түүнд саналаа өгөх магадлал өндөр байгаа. Ингэж тооцвол, түүнд ч гэсэн намынхны олонхийн дэмжлэгийг авч дараагийн Ерөнхий сайдаар томилогдох боломж бий. Түүний хувьд өмнө нь Лондон хотын захирагчаар ажиллаж байсан. Гэхдээ Тереза Мэйг бодвол туршлагагүй хэмээн шүүмжлүүлэх нь бий. Харин Британийн хүчтэй улстөрч Борис Жонсон тэргүүтэй түүнийг дэмжигчид "Дэвид Камерон ч гэсэн Ерөнхий сайдаар томилогдохоосоо өмнө туршлагагүй нэгэн байсан" гэдгийг тодотгож байна. Мөн түүний санхүүгийн салбар дахь туршлагыг онцолж байгаа юм.

Юаний ханш суларлаа

БНХАУ-ын албан ёсны мөнгөн тэмдэгт болох юаний валютын зах зээл дэх ханш суларсаар байна. Европын эдийн засгийн хэтийн төлөв анхааруулах шугамд ойртож буй энэ үед Хятадын эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор мөнгөн тэмдэгтийнх нь үнэ буурсаар байгаа аж. Хятадын төв банкны мэдэгдсэнээр өдөр ирэх бүр ам.доллартай харьцах ханш нь суларсаар буй гэнэ. Өчигдрийн байдлаар гэхэд нэг ам.доллар 6.6857 юаньтай тэнцэж байв. Үүнийг өмнөх өдөр буюу энэ сарын 5-ны өдрийнхтэй харьцуулбал 0.4 хувиар буурчээ. Ингэснээр 2010 оны арваннэгдүгээр сараас хойш бараг таван жил найман сарын хугацааны дараа юаний ханш суларсан үзүүлэлттэй гарч байна. Тэгвэл юаний ханш суларсан сургаар очигдрөөс эхлэн Шанхайн гадаад валютын зах зээлд юанна зарж, ам.доллар худалдан авах хөдөлгөөн эрчимжжээ. Валютын зах зээлд ажиллах нэгэн эрхэм "Их Британичууд Европын холбооноос гарах эсэх талаархи бүх нийтийн санал асуулгад гарах сонголт хийсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдын дунд эрсдэлээс зайлсхийх хөдөлгөөн идэвхижсэн. Үүний улмаас зах зээлд Хятадын эдийн засгийн байдал илүү эмзэг болж эхэлснээр ихэнх хүмүүс юанна зарж борлуулах хандлагатай болчихлоо" гэж ярьжээ.

Австрийн Ерөнхийлөгчийн дахин сонгуулийн тов гарчээ



Австрийн Ерөнхийлөгчийн шийдвэрлэх шатны сонгууль өнгөрөгч тавдугаар сард болж, нийт сонгогчдын 50 гаруй хувийн саналыг авсан "Ногоон" намын удирдагч асан Александр Ван дер Беллен ялалт байгуулсан билээ. Тодруулбал, нийт сонгогчдын 50.35 хувь нь түүнийг дэмжсэн бол хүчтэй өрсөлдөгч болох Австрийн Эрх чөлөө намаас нэр дэвшигч Норберт Хофер 49.64 хувийн санал авсан юм. Хоёр өрсөлдөгчийн саналын зөрүү нэг хувиас ч бага байсан төдийгүй ердөө 31 мянган иргэний саналын зөрүүтэй байсан. Сонгуулийн сүүлчийн мөч хүртэл ялалтдаа итгэлтэй байсан Хофер албан ёсны үр дүн зарлагдахын өмнөхөн ялагдлаа хүлээн зөвшөөрч байв. Тэгвэл

энэ сонгууль будилаантай болсон гэх шалтгаанаар тус улсын Ерөнхийлөгчийн сонгууль дахин зохион байгуулагдахаар болж, өдөр нь хүртэл товлгогджээ. Учрыг тодруулбал, сонгуульд ялагдсан Эрх чөлөө намын зүгээс шуудангаар авсан 31000 орчим санал асуулга бүгд алдаа дутагдалтай байсны зэрэгцээ 117 тойргийн 97 тойрогт сонгуулийн мэдээлэл буруу байгаад зогсохгүй 16-аас доош насныхан болон гадаадын иргэд сонгууль өгсөн хэмээн Үндсэн хуулийн шүүхэд хандсан аж. Шүүх хоёр долоо хоногийн турш 90 гаруй гэрчүүдтэй уулзаж, улмаар тус сонгуулийг хүчингүй болгож, улс даяар ирэх аравдугаар сарын 2-ны өдөр дахин сонгууль хийхээр шийдвэрлэжээ.

"Apple" донор бүртгэх апп гаргана

АНУ-ын мэдээллийн технологийн "Apple" корпораци эрхтэн шилжүүлэн суулгах зайлшгүй шаардлага бүхий хүнд өвчтөнүүдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ухаалаг утасны донор бүртгэх боломжтой апп-ыг гаргажээ. Тус апп энэ намраас эхлэн АНУ-д хэрэглэнд нэвтрэх юм байна. Донорууд уг апп-д хандсанаар АНУ-д эрхтэн шилжүүлэх суулгах чиглэлээр иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг "Donate Life America" байгууллагатай шууд холбогдох бөгөөд маш хялбараар Донорын бүртгэлд бүртгэгдэх юм байна.

Одоогийн байдлаар 120 гаруй мянган өвчтөн эрхтэн шилжүүлэн суулгуулах зайлшгүй шаардлагатайгаар хүнд өвчнөөр шаналж буй гэсэн тоон мэдээлэл байдаг. Тиймээс "Donate Life America" төрийн бус байгууллага "Apple" корпорацитай донор бүртгэх апп гаргахад хамтран ажиллажээ. Тус ТББ-д бүртгэлтэй донорын тоо нэмэгдсэнээр олон хүний амь нас аврагдах боломжтой болно гэж холбогдох албаныхан онцолж байна. "Apple" корпорацийн үүсгэн байгуулагч, таван жилийн өмнө нас барсан Стив Жобс ч мөн элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэж байсан ч, яг тохирох донор олж чадаагүй байдаг. Тухайн үед түүний дор ажиллаж байсан СЕО Тим Кук ч гэсэн Стив Жобсын донор болох санал тавьж байсан удаатай гэнэ.

Төрийн мэдээллийн үйлчилгээний төв

Дэгийг тусгаж авч байна

Улаанбаатар орондоо дугуйн цаантай болгох санхүүжилтийг үргэлжлүүлж байна

Төлөөлөгч

MINFO.mn сайтаас

06 сарын 30 (Долоо)

Улаанбаатар 1990

Цэцэг хуудас 30 минутын өмнө шинэчлэгдсэн.

Одриня Нэтридж

охиной боллоо

Дэлгэрэнгүй мэдээллийг MINFO.MN сайтаас

ШУУРХАЙ МЭДЭЭ

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ГОЛ УСНЫ АЮУЛААС СЭРЭМЖЛҮҮЛЭЭ

Ойрын өдрүүдэд ихэнх нутгаар цаг агаар 30-35 хэм хүртэл халж, бүгчм халуун байгаатай холбоотойгоор иргэд гол ус бараадан амарч зугаалах нь их болсон. Ингэхдээ санамсаргүй байдлаар усанд осолдох, амиа алдах тохиолдол буурахгүй байгаа ажээ. Тиймээс наадмын амралтын өдрүүдэд аялал, амралтаар явахдаа гол усны ойролцоо амарч зугаалахгүй, сонор сэрэмжтэй байж, бага насны хүүхдийг гол усны эрэг дагуу явуулж, тоглуулахгүй байх, хүүхдэд тавих хараа хяналтаа дээшлүүлэх, баталгаатай гүүр, гарам, гарцтай газраар автомашинтай зорчиж, аюулгүй байдлаа хангахыг Онцгой байдлын ерөнхий газраас нийт ард иргэддээ онцгойлон анхаарууллаа.

Наадамчдад автобус үнэгүй үйлчилнэ

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810 жил, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр ажиллах нийтийн тээврийн үйлчилгээний төлөвлөлт гарчээ. Тодруулбал, баяр наадмын өдрүүдэд хот доторх болон хотын орчмын 82 чиглэлд их багтаамжийн 660, туслах есөн чиглэлд бага багтаамжийн 49, зуслангийн гурван чиглэлд тав нийтдээ 714 автобус үйлчилгээнд явах ажээ. Үүнээс Төв цэнгэлдэх хүрээлэн орох наадамчдад зориулж “Мишээл экспо” төв рүү нийт найман чиглэлийн 59 автобус, “Дунжингарав төв” рүү 24 чиглэлийн 167 автобус үйлчлэх юм байна. Харин “Мишээл экспо төв” болон “Дунжингарав худалдааны төв”-өөс “Төв цэнгэлдэх хүрээлэн” рүү 15 автобус дөрвөн минут тутамд, Рейлбусын зогсоол буюу “Урбанек”-ын урд талын “Дунд гол”-ын зогсоолоос Төв цэнгэлдэх хүрээлэн рүү гурван

автобус таван минут тутамд, Хүй долоон худгийн Рейлбусны зогсоол буюу “Давааны зөрлөг”-өөс Морь тарианы газар руу таван автобус дөрвөн минут тутамд тус тус богино эргэлтээр наадамчдад үнэ төлбөргүй үйлчлэх юм байна. Мөн Гандийн гудамжны автобусны зогсоолоос, хотын төв буюу “МУБИС”-ийн баруун тал буюу “Улаанбаатар зочид буудал”-ын автобусны зогсоолоос 08:00 цагаас 20 их багтаамжийн автобус, 20 минут тутамд, “3,4-р хороолол”, “7 буудал”, “5 шар”, “ХМК”, “Оффцеруудын ордон”-ны зогсоолуудаас тус бүр дөрвөн бага багтаамжийн автобус “Хүй 7 худаг” руу 1000 төгрөгийн тарифаар иргэдэд үйлчлэх ажээ. Рейлбус мөн хөнгөлөлттэй үнээр иргэдэд үйлчлэх бөгөөд энэ сарын 10, 11, 12, 13-ны өдрүүдэд “Амгалан”-гаас “Давааны зөрлөг” хүртэл Рейлбус 500 төгрөгийн төлбөртэй байх юм байна.

“Дээлтэй Монгол” наадам энэ ням гарагт болно

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран 10 дахь жилдээ “Дээлтэй Монгол наадам” үйл ажиллагааг энэ сарын 10-ны өдрийн 16:00 цагт Чингисийн талбайд зохион байгуулах гэж байна. Тус наадам нь үндэсний хувцас, гоёл чимэглэл дэлхийд гайхуулан сурталчлах томоохон баяр болж өргөжөөд байгаа билээ. Энэ жилийн “Дээлтэй Монгол” наадмын ерөнхий найруулагчаар нийслэлийн Улаанбаатар чуулгын дарга Р.Мөнхсайхан ажиллах юм. Наадмын энэ жилийн гол онцлог нь дотоодын загварын шинэ брэндүүд, өдөр тутам өмсч болох үндэсний хэв маягтай залууст зориулсан коллекциудын нэгдсэн загварын шоу ороулснаас гадна найруулагчийн шийдлээр зорин ирсэн хэн бүхэнд үзүүштэй урлагийн шоу тоглолт толилуулахаар бэлдэж байна. Өмнөх жилүүдийн адил Нийслэлийн дүүргүүдийн шилдэг үндэсний хувцастай парад алхана. Мөн оролцогчдоос гурван номинацид шилдгүүдэд тодруулж, шилдэг зохион байгуулалттай оролцсон дүүрэг, шилдэг үндэсний хувцастай хос, шилдэг үндэсний хувцастай гадаад оролцогчийг шагнаж юм. Наадмын үеэр Чингисийн талбайд төрөл бүрийн соёл урлагийн арга хэмжээнд өргөнөөр оролцож амралтын нэг өдрийг Монгол бахархал болсон дээл хувцсаараа гоёж өнгөрөөхийг нийслэлчүүддээ уриалж байна.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Автомашинны зөвшөөрлийг олгож эхэллээ

Б.НОМИН

Төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоо худаг дахь авто зогсоолын талбайн хэмжээгээр тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг Замын цагдаагийн газраас иргэд, жолооч нарт олгодог. Тэгвэл энэ жилийн хувьд А, ДК, D, Ж, улаан М, цэнхэр М, шар У, ногоон У, Г гэсэн зөвшөөрлийг олгож эхэлжээ. Тухайлбал, Төв цэнгэлдэх хүрээлэнд А, ДК, Г, шар У, Ж зөвшөөрөлтэй машинууд нэвтрэх бөгөөд А болон ДК зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл нь Төв цэнгэлдэх хүрээлэнгийн баруун талд байрлах шинээр баригдсан зургаан давхар автомашин зогсоолд байрлах юм байна. Харин Г, шар У зөвшөөрөлтэй бол Нийслэлийн гудамж буюу Хурд



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хорооллын урд байрлах “Сугура Монгол” ХХК-ийн талбайд, Ж зөвшөөрөлтэй автомашин Гандийн гудамж буюу Төв цэнгэлдэх хүрээлэнгийн чанх хойно байрлах “Говийн Ол” ХХК-ийн зогсоолд

байрлана. Зөвшөөрөл авч амжаагүй жолооч нарын хувьд явтомашиннаа Дунжингарав, Мишээл экспо төвийн зогсоолд байрлуулан төв цэнгэлдэх рүү автобусаар үнэ төлбөргүй зорчих боломжтой гэдгийг

Замын цагдаагийн газрын газраас мэдээллээ. Дашрамд дурьдахад, Хүй долоон худаг руу Ж, А, ДК, улаан, цэнхэр М, ногоон У зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой юм байна.

АСЕМ-ЫН ҮЕЭР ЦАГДААГИЙН 5000 АЛБАН ХААГЧ АЖИЛЛАНА

Б.НОМИН

АСЕМ-ын 11 дүгээр дээд хэмжээний уулзалтын үеэр цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар Цагдаагийн ерөнхий газрын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга, туслах комиссар П.Энхтөгтохоос зарим зүйлийг тодрууллаа.

-АСЕМ-ын 11 дүгээр дээд хэмжээний уулзалтын үеэр цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний бэлтгэл ажлын гүйцэтгэл хэдэн хувьтай явж байна вэ?

-Ази Европын 11 дүгээр уулзалтаар ирэх зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2014 оны арванхоёрдугаар сараас бэлтгэл ажил эхэлсэн. Бэлтгэл ажлын хүрээнд 19 бүлэг 125 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Бэлтгэл ажил 91.5 хувьтай явж байгаа. Үндсэндээ хурлын аюулгүй байдлыг хангаж ажиллахад цагдаагийн байгууллага бэлэн болсон гэж хэлж болно.

-Уулзалтын үеэр цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа ажлуудаас дурьдвал?

-Монгол Улсад зохион байгуулагдах энэ дээд хэмжээний хурал дэлхий нийтэд манай орныг сурталчлах, хөрөнгө оруулалт татах томоохон ач холбогдолтой. Иймд зөвхөн цагдаагийн байгууллагаар зогсохгүй төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж байна. Төрийн байгууллагаас хамгаалалтын ажиллагаанд ашиглах техник технологийг нэвтрүүлсэн. Мөн АСЕМ-ын хурлын үеэр буюу

...АСЕМ-тай холбоотой иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хотоос нүүлгэнэ гэсэн мэдээлэл цацагдаж байсан. Энэ үнэн үү?

-Худал мэдээлэл. Тодорхой хамгаалалт хийх газруудаараа цагдаагийн байгууллагын албан хаагчид хамгаалалтад гарах болно...

хурлын дараа хэрэглэгдэх эргүүлийн автомашин 52 приус машинаар нэмэгдсэн байгаа. Хууль зүйн сайдын тушаалаар олон нийтийг хамарсан урлаг соёл, сонгууль, баяр наадмын хамгаалалтын үед ажиллах бүрэн тоноглогдсон Нэгдсэн удирдлагын төв буюу нэгдсэн штабтай болсон. Түүнчлэн бэлтгэл ажлын төлөвлөгөөтэй

уялдуулан цагдаагийн байгууллагаас хэд хэд том ажлыг гүйцэтгэлээ.

-Уулзалтын үеэр цагдаагийн байгууллага хэдэн хүний бүрэлдэхүүнтэй ажиллах вэ?

-Цагдаагийн байгууллагуудаас 5000 орчим албан хаагч ажиллана. Үүнээс төв орон нутгийн цагдаагийн газрын хэлтсээс замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хэв журам сахиулах чиглэлээр 570 орчим алба хаагчид нэмэгдээр оролцуулж байгаа. Мөн олон нийтийн цагдааг 224, оюутан цагдаа 130, сайн дурын 150 орчим иргэн хамгаалалтын үйл ажиллагаанд татаж оролцуулахаар болсон. Өөрөөр хэлбэл, баяр наадам болон АСЕМ-тай холбогдуулан энэ сарын 9-18-ны хооронд иргэд болон АСЕМ-ын зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс цагдаагийн байгууллага өндөржүүлсэн бэлэн байдалд шилжж ажиллахаар болж байна.

-Цагдаагийн алба хаагчдад АСЕМ-тай холбоотой сургалт явуулсан гэсэн. Ямар ямар сургалт явуулсан бэ?

-Ээлж дараатай олон төрлийн сургалт зохион байгуулсан. Ялангуяа аюулгүй байдлыг хангах чиглэлд анхаарсан. Мөн гэмт хэргийн зөрчлийн талаар мэдээ мэдээлэл авах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, хамгаалалтын үед ажиллах болон цагдаагийн байгууллагын ажилтны хувийн ур чадварыг дээшлүүлэх талаар сургалтууд орсон. Түүнчлэн шинэ дэвшилтэт техник, технологийг ашиглах чиглэлээр сургалтууд орж

байна. Олон нийтийн цагдаа болон оюутан цагдаа, сайн дурынханд хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой сургалт орсон байгаа.

-Замын хөдөлгөөнийг хэрхэн зохицуулах вэ. Зам хаах уу?

-Хамгаалалтын бүсүүд зарлагдсан. Үүнд “АСЕМ Вила” хотхон, нисэх буудал руу явах чиглэл, Шангри-Ла зочид буудал эерэг хурлын арга хэмжээ болох газруудаар тодорхой хэмжээгээр хуваарийн дагуу замууд хязгаарлагдана. Гэхдээ иргэдийг замын хөдөлгөөнөөр зорчиход хүндрэл учруулахгүй байх үүднээс Төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжид заасны дагуу зохицуулсан байгаа. Гэхдээ тодорхой хэмжээгээр иргэд эдгээр цагуудад өөрсдийн ажлаа зохицуулахад анхаарах хэрэгтэй. Түүнчлэн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр урьдчилсан байдлаар Улаанбаатар хотын дотор 1100 орчим камерыг хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглахаар суурилуулсан.

-АСЕМ-тай холбоотой иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хотоос нүүлгэнэ гэсэн мэдээлэл цацагдаж байсан. Энэ үнэн үү?

-Худал мэдээлэл. Тодорхой хамгаалалт хийх газруудаараа цагдаагийн байгууллагын албан хаагчид хамгаалалтад гарах болно. Ямар ч нүүлгэлт шилжүүлэлт хийхгүй, мөн иргэдийн хөдөлгөөнийг ч хязгаарлахгүй.

-Дугаарын хязгаарлалтад өөрчлөлт орох уу?

-Дугаарын хязгаарлалт өмнөх зарчмаараа явна.

Хүний аминд хүрсэн нохойг устгаж, эзэнд нь ял оноов

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутагт, хашаандаа сул байсан Дундад Ази үүлдрийн нохой дөрвөн настай хүү рүү дайрч, хэсаны улмаас хүү амиа алдсан харамсалтай хэрэг өнгөрсөн гуравдугаар сард гарсан билээ. Тэгвэл Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс иргэн Б-г буруутай хэмээн үзэж 2.6 жилийн хорих ял оноосон байна. Мөн хүүхэд хазаж, аминд нь хүрсэн Дундад Ази үүлдрийн нохойг устгажээ. Хэргийг эргэн сануулбал, тухайн үед хүү гэрээсээ гарч, хоёр хашаны цаана байх эмээгийнх рүүтээ гүйж явахдаа нохойд уруулж, эмнэлгийн тусламж авсан ч шархаа даалгүй нас барсан билээ.

ЗАР ЗАР ЗАР

Ар-Гүнтийн зусланд модны дэргэд байрлалтай 8*10 хэмжээтэй дүнзэн торхтой зуслангын газрыг зарна.

Үнэ: 25 сая
Утас: 98989089

Max speed

Гүний худаг ӨРӨМДӨНӨ

Таны хүссэн газарт хурч ажиллана

Макс Спийт ХХК

УТАС: 88008954, 88008953

БГД, 18-р хороо, III, IV хороолол Ард Аюулийн гудамж, УБ

ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

Курдын эмнэлэг дэх хэт даврагч



Б.ДАВАА

Зураг дээрх битүү түлэгдсэн хүүг Иакоб гэдэг. Тэрбээр 16 настай бөгөөд өөрийгөө хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн дайчин гэж танилцуулжээ. Харин түүний хажууд зогсч, түлэнхийд нь тос түрхэх эрэгтэй бол Сирийн хойд этгээдийн Аль Хасака дахь эмнэлгийн эмч. Эмнэлгийн давчуу өрөөний арын хананд нь Курдын ажилчны намын тэргүүн Абдуллах Оканы томоос том

зураг мөн өлгөөтэй байх ажээ. Сирийн хойд этгээд дэх Курдын хүчин болон хэт даврагч бүлэглэлийн хоорондын дайны хохирогч болсон өсвөр насны хүү, түүнийг эмчлэх эмч гээд эмнэлгийн нэгэн агшны дүр төрхийг Бразилийн гэрэл зурагчин Маурисио Лима 2015 оны наймдугаар сарын 1-нд дурандаа буулгасан байна. Иакоб хүүгийн хэвтэж буй эмнэлэг Курдын өөрийгөө хамгаалах хүчний хяналтад байдаг байна. 2014 оноос хойш Сири, Иракийн хойд этгээдийн нутгууд руу

довтолж, "Халифын вант улс" байгуулснаа зарласан "Лалын улс" бүлэглэл эзэмшил нутгаа өргөжүүлэхээр Курдынхны хяналт дахь тухайн бүс нутаг руу халдаж, улмаар Курдын арми өмнөөс нь сөржээ. Тухайн үед Лалын улс бүлэглэл Сирийн хойд хэсгийн ихэнх нутгийг хяналтдаа авсан байсан бөгөөд Ракка, Алеппо зэрэг хотуудад ч аль хэдийнэ хяналтдаа тогтоогоод байлаа.

Газар нутгийн төлөөх яг энэ тулааны хохирогч нь Иакоб. Тэрбээр Аль Хасака хотын зах хэсэгт гарсан Курдын

хүчнийхний отолгод өртжээ. Түүнтэй хамт "Лалын улс" бүлэглэлийн таван дайчин хамт явсан ч, Иакоб ганцаараа амьд үлдсэн байна.

Энэ зураг Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах "World press photo-2016" 59 дэх удаагийн тэмцээний "Ерөнхий мэдээ" төрөлд тэргүүн байр эзэлжээ. Тус наадамд 128 орны 5775 зурагчний шилдэг 82915 бүтээлээс шилдгээр шалгарч, дайны гашуун түүхийг дэлхий дахинаа харуулж чадсан байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 34
Шөнө 18

Нөгөөдөр
Өдөр 34
Шөнө 20

Өдрийн зурхай

2016.07.06 / БИЛГИЙН ТООЛЛЫН 2


Зуны адаг хөхөгчин хонь сарын Есон улаан мэнгэтэй шарагчин үхэр өдөр



Аргын тооллын 7 сарын 6, Буд гараг. Билгийн тооллын 2, Найралт эх одтой, шарагчин үхэр өдөр. Өдрийн наран 5 цаг 03 минутад ландан, 20 цаг 48 минутад жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие эхрүүлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус туулах, хишиг далага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг дахах, газрын ал бооход сайн. Эрдэнийг гадагш огох, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь баг, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТЭНГИС
КИНО ТЕАТР

Хүний амьдралын түүх бол зөвхөн хайрын түүх юм. Үзэсгэлэн төгс Үүлэнсолонго, баян эцгийн өв залгамжлагч Уран, бүгдийг зохицуулагч Содоо, нууцлаг бүсгүй Анна нарыг нэгтгэсэн зүйл нь юу вэ? Хайр хүний сэтгэлийн өөрчлөн эзэмддэг шигээ амьдрал хувь тавилан, нөхөрлөл, ирээдүйг ч бас өөрчлөж чаддаг. Бүгдийг гайхшруулах нэгэн ээдэрээт тавилан, сэтгэл хөдөлгөм бодит түүхээс сэдэвлэсэн "Хөөрхөн шулам" кино таны хайрын тухай ойлголтыг өөрчлөх болно. Шулам төрдөггүй, шулмыг гарцаагүй амьдралын шаардлага бий болгодог юм.



Жилд нэг удаа 12 цагийн турш аллагын гэмт хэргийг зөвшөөрдөг Цэвэрлэгээний хуультай байна. Өмнө нь цагдаагийн дэслэгч байсан Барнес хүүгээ алсан хүмүүсийн алахгүй өршөөхөөр шийднэ. Хоёр жилийн дараа ерөнхийлөгчийн сонгуулийн гол өрсөлдөгч, Цэвэрлэгээний хуулийг эцэслэхээр сонгуулийн мөрийн хөтөлбөрөө болгосон Сенатын гишүүн Чарлин Роаны хамгаалалтыг албыг ахална.



Тусгаар тогтнолын өдрөөр харь гаригийнхан дайрснаас хойш хүн төрөлхтөн тэдний технологийг ашиглан шинэ хамгаалалтын системтэй болно. Гэвч өмнөхөөсөө илүү хүчтэй дайралт ирлээ. Бидний хамгаалалт найдвартай байж чадах болов уу.

ТУН УДАХГҮЙ "ТЭНГИС"-ИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарах хугацаа 2016.07.08



Гарах хугацаа 2016.07.22



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.08.05